

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

(Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Сангийн яамны сайтад байршуулсан
2022 оны нэгдүгээр сарын 5-ны хувилбарт хамаарна)

Монгол Улсын иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт¹ зааснаар төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Тус эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011 он), Шилэн дансны тухай хууль (2014 он) чухал үүрэг гүйцэтгэсэн. Үүнээс Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021 он) 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна.

Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын 2022 оны 8 дугаар тогтоолын² 49-рт Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тусгаж, хаврын ээлжит чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн дагуу Сангийн яамнаас Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (Шинэчилсэн найруулгын төсөл) боловсруулж, цахим хуудсандаа нийтэлсэн³.

УИХ-ын 2020 оны 2 дугаар тогтоолоор⁴ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн⁵ агуулга, үзэл санаанд нийцүүлж эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхийг буюу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар “төрийн нийтийн өмч”-ийн зохицуулалтыг тодорхой болгох, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар УИХ-аас төсвийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгохыг Засгийн газарт даалгасан. Тодруулбал, тогтоолын хавсралт “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.2.5-д “төрийн санхүү, төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх

- ¹ Монгол Улсын Үндсэн хууль. Арван зургадугаар зүйл, 17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;
- ² Улсын Их Хурлын 2022.1.18-ны өдрийн “Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 8 дугаар тогтоол (<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390150786561>).
- ³ Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (<https://mof.gov.mn/discussion/1348>)
- ⁴ Монгол Улсын Их Хурлын 2020.1.9-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2 дугаар тогтоол (<https://legalinfo.mn/mn/detail/14950>).
- ⁵ 2019.11.14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулсан.

байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох” гэж, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох” гэж даалгасан хүрээнд олон нийтийн хяналтын зохицуулалтыг тодорхой болгох шаардлага үүссэн.⁶

Шинэчилсэн найруулгын төсөл нь нийт 3 бүлэг, 11 зүйлтэй, шилэн дансны зарчим, мэдээлэл хүргэх хэлбэр, мэдээлэх албан тушаалтан, хэрэгжилтэд хяналт тавих, иргэний хяналт, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэрэг зохицуулалтын ихэнх агуулгыг хэвээр үлдээсэн байна. Тиймээс Шинэчилсэн найруулгын төслийг бүхэлд нь судалж, шинээр нэмсэн болон өөрчилсөн зохицуулалтыг хуулийн үйлчлэлд хамаарах эрх зүйн этгээд, мэдээлэх мэдээллийн агуулга, хүрээ, мэдээлэл хүргэх зарчим, давтамж, шилэн дансны нийтлэг стандарт, хяналт, хариуцлага, бусад хууль тогтоомжид төсөв, санхүүгийн мэдээллийг нийтэд мэдээлэхэд хамаарах зохицуулалт гэж хүрээг тодорхойлж, иргэний нийгмийн байгууллагуудын санал, мэргэжлийн судлаач, зөвлөхүүдийн гаргасан саналыг харгалзан, Өмгөөллийн Фиделитас партнерс ХХН-ийн судалгааны баг хуулийн төсөлд санал, шүүмж бэлтгэлээ.

НЭГ. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан зохицуулалтыг бидний зүгээс дараах хүрээнд ангилж, өөрчлөлт оновчтой эсэхэд дүгнэлт хийн, хуулийн төслийг боловсронгуй болгоход чиглэсэн санал гаргалаа.

1.1. Хуулийн үйлчлэлд хамаарах эрх зүйн этгээд, түүний эд хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтны хамрах хүрээг тодорхойлсон нэмэлт, өөрчлөлт

1.1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэж заасныг Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гээд 3.1.1.а-д “төрийн байгууллага, албан газар”, 3.1.1.б-д “нийтийн байгууллага” гэж салгаж тодорхойлсон. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг хассан.

Иргэний нийгмийн байгууллагаас өгсөн санал:

- 1) Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах субъектийг оновчтой тодорхойлоход анхаарах нь зүйтэй байна. Тодорхойлолтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (ТБОНӨтХ), Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтад нийцүүлж тодорхойлох;
- 2) Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2-т төрийн өмчит үйлдвэрийн газар хуулийн үйлчлэлд хамаарахаар давхардуулсан, давхардлыг арилгах.

(Сангийн яам, 2021)

⁶ https://mof.gov.mn/files/uploads/article/2.%D2%AE%D0%B7%D1%8D%D0%B_%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC%D1%82%D0%BB%D0%B0%D0%B_%D0%A8%D0%B8%D0%BB%D1%8D%D0%BD_%D0%B4%D0%B0%D0%BD%D1%81_.pdf

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэлд хамаарах эрх зүйн этгээд, эрх бүхий албан тушаалтныг дахин томьёолж давхардлыг арилгасан байх хэдий ч Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “*төрийн болон орон нутгийн өмчит нийтийн эрх зүйн хуулийн этгээд: 3.1.1.а.төрийн байгууллага, албан газар; 3.1.1.б. нийтийн байгууллага*” гэж заасан нь онолын тодорхойлолт болон ТБОНӨТХ-ийн 13 дугаар зүйлд “*төрийн өмчит хуулийн этгээд*” гэсэн нэр томьёо, бусад хууль тогтоомжийн заалттай нийцэхгүй.

Тодруулбал, нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж нийтийн эрх зүйн хүрээнд хууль болон захирамжилсан шийдвэрийн үндсэн дээр зохион байгуулагддаг, нийтийн эрх зүйн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг этгээдийг ойлгох бөгөөд (1) гишүүнчлэл бүхий нэгдэл, (2) албан газар, (3) нийтийн эрх зүйн сан гэж төрөлжүүлэн ангилдаг⁷.

Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд захиргааны байгууллагыг “*Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно*” гэж тодорхойлсон бөгөөд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “*нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар*” зэргийг бүртгэхээр заажээ. Иймд Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1.б-д нийтийн байгууллага гэж заасан нь нийтийн эрх зүйн ямар этгээд, ямар байгууллага тус ангилалд хамаарахаар байгаа нь ойлгомжгүй байна. Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “*нийтийн эрх зүйн хуулийн этгээд*”-ийг төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас тусад нь хуульчилсан. Иймд уг ангиллыг тусад нь оруулах шаардлагатай.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1.б. “*нийтийн байгууллага*” гэснийг “*нийтийн эрх зүйн бусад хуулийн этгээд*” гэж өөрчлөх;

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “*төрийн өмчит үйлдвэрийн газар*” гэж нэмэх;

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 - 3.1.5 дахь хэсгийн дугаарлалтыг өөрчлөх.

- 1.1.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “*хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани*” гэж тусдаа тодорхойлсныг Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “*төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд*” гээд 3.1.2.а-д “*хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани*” гэж нэг төрөл нь байхаар салгаж, 3.1.2.б-д “*хяналтын багцаас бага хэмжээний хувьцааг нь төр болон орон нутгийн өмчит хуулийн этгээд эзэмшиж байгаа улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлдэг том аж ахуйн нэгжийн ангилалд багтдаг, эсхүл төрөөс үйл ажиллагааны татаас, санхүүгийн батлан даалт, олон улсын зээл тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа компани*” гэж нэмж тодорхойлсон.

⁷ П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. 3 дахь хэвлэлт, УБ., 2016, 95 дахь тал.

Иргэний нийгмийн байгууллагаас өгсөн санал:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын нэршил, ангиллыг оновчтой байдлаар тодорхойлж бусад хууль тогтоомжид заасан нэршил, ангилалтай уялдуулан боловсронгуй болгох;

(Нээлттэй Нийгэм Форум, 2021)

Түүнчлэн хэмжээ, төрийн оролцооны хувь, албан ёсоор бүртгүүлсэн хэлбэр зэргээс үл хамааран бүх төрийн өмчит аж ахуйн нэгж тайлан гаргах явдлыг эрх зүйн хүрээнд шийдэх шаардлагатай.

(Н.Дорждарь, 2022)

Дээрхээс үзвэл нэршлийн хувьд Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс ялгаж хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж тодотгосноос гадна 3.1.2.б-д хяналтын багцаас бага хэмжээний хувьцаа эзэмшдэг ч улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлдэг том аж ахуйн нэгж, эсхүл төрөөс үйл ажиллагааны татаас, санхүүгийн батлан даалт, олон улсын зээл, тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа компанийг нэмж тодорхойлсон нь дэвшилттэй болсон байна.

Харин ийнхүү өөрчлөхдөө “том аж ахуйн нэгжийн ангилалд багтдаг” гэж тодорхойлсон бөгөөд Сангийн сайдын 2016 оны 41 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тогтоох журмын 3.4-т тухайн жилийн санхүүгийн тайланд нийт хөрөнгийн хэмжээ 0.5 тэрбум төгрөгөөс дээш, эсхүл борлуулалтын хэмжээ 1.5 тэрбум төгрөгөөс дээш байх шаардлагын аль нэгийг хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг “том аж ахуйн нэгж, байгууллага” гэж тодорхойлсон.

Тухайн жилийн борлуулалтын орлого, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн хэмжээнээс үл хамааран төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд шилэн дансны хуулийн үйлчлэлд хамрагдаж, шилэн дансанд мэдээлэл оруулснаар төсвийн ил тод, нээлттэй байдал хангагдана.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2.б. “хяналтын багцаас бага хэмжээний хувьцааг нь төр болон орон нутгийн өмчит хуулийн этгээд эзэмшиж байгаа улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэхэд оролцдог, эсхүл төрөөс үйл ажиллагааны татаас, санхүүгийн батлан даалт, олон улсын зээл тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа компани” гэж өөрчлөх.

1.1.3. Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “Засгийн газар, орон нутгийн тусгай сан” гэж нэмсэн.

Шилэн дансны тухай хуулийн 3.1-д хуулийн үйлчлэлд хамаарах субъект буюу байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Засгийн газрын тусгай сан гэж Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг” гэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.17-д “Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн; 18 дугаар зүйлийн 18.1-д “Төрийн болон орон нутгийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгай сангаар дамжуулан гүйцэтгэж болно”, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох

шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу **байгууллагын цахим хуудас** болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ” гэж зааснаас үзэхэд Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан нь Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан эрх зүйн этгээд буюу байгууллагад хамаарахаар байна.

Иргэний нийгмийн байгууллагаас өгсөн санал:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан сан нь Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “Засгийн газар, орон нутгийн тусгай сан” гэж тодорхойлсонд багтана. Иймд мэдээлэл байршуулах үүрэг бүхий этгээдийн хүрээнд “Засгийн газрын тусгай сан”-г тодорхойлох;

(Сангийн яам, 2021)

Засгийн газрын тусгай сангийн төсөв зарцуулах үйл ажиллагааг ил тод мэдээлэх талаар хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай.

(Үнэн хатамж ТББ, 2018)

Дээрхээс үзвэл Засгийн газрын тусгай сангийн төсөв зарцуулах үйл ажиллагааны мэдээллийг мэдээлэх зохицуулалтыг хуульчлах саналыг Шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан байна.

1.1.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “... гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “... гүйцэтгэж байгаа этгээд” гэж улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэгчийг өөрчилж тодорхойлсон.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “аж ахуйн нэгж” гэх ойлголтод төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон ... дотоод, гадаадын хуулийн этгээдийг хамруулж тодорхойлсон. Нөгөөтээгүүр байгууллага гэх ойлголтод эрх бүхий төрийн байгууллагыг ч хамааруулан ойлгоно. Иймд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан “гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага” гэх тодорхойлолт нь өргөн хүрээг хамарсан, Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагыг хамруулахаар байх тул дээрх заалтад өөрчлөлт оруулсан байна.

Иргэний нийгмийн байгууллагаас өгсөн санал:

Мэдээлэл байршуулах үүрэг бүхий этгээдийн хүрээг дараах байдлаар тодорхойлох:

1. захиргааны байгууллага буюу төрийн байгууллага, албан газар;
2. төрийн өмчит үйлдвэрийн газар;
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан сан;
4. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
5. хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;
6. улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа этгээд;
7. төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч;
8. гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, Төсвийн тухай хуулийн хүрээнд 14.2.7.өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага;
9. дээрх этгээдүүдэд холбогдох салбар, төлөөлөгчийн газар;

(Сангийн яам, 2021)

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх үүрэг хүлээсэн төрийн нийтийн өмчийн хөрөнгийн санхүүжилтээр концесс, тендер, төсөл, арга хэмжээ, ажил үйлчилгээ явуулж байгаа иргэн, хуулийн этгээдүүдэд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

(Нээлттэй Нийгэм Форум, 2021)

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.6-д “Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж” гэх мэдээллийг ил тод болгохоор тусгасан бөгөөд уг санхүүжилтийг хариуцан хэрэгжүүлэгчийг Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан субъектэд оруулаагүй нь зохицуулалтыг тодорхойгүй болгоно. Иймд мэдээлэх үүрэгтэй этгээдэд улсын төсөвт тусгагддаг эдгээр төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэгчийг нэмж оруулах шаардлагатай.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д “Засгийн газар, орон нутгийн байгууллага болон Засгийн газраас бусад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй, улсын төсөвт тусгагддаг зээл, буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэгч ажлын алба, ажлын хэсэг, төслийн нэгж” гэж өөрчлөх.

- 1.1.5. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д “төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д “төрийн чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд” гэж найруулсан.

Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд”-ийг захиргааны байгууллага гэж ойлгохоор тодорхойлсонд нийцүүлэн энэ заалтыг өөрчлөн найруулсан байна.

1.2.Хуулийн үйлчлэлд хамаарах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийн агуулга, хамрах хүрээг тодорхойлсон нэмэлт, өөрчлөлт

1.2.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “... холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2-т “... холбоотой мэдээлэл хамаарна” гэж төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг гүйлгээгээр хязгаарлахгүй тодорхойлсон.

1.2.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1-д “улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.1-д “улс, орон нутгийн төсөв” гэж өөрчилсөн.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.11-д “Нийгмийн даатгалын сан” нь тусгай сангийн төрөл байхаар хуульчилсан. Иймд Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.3-т Засгийн газрын тусгай санг дурдсан тул тусгай сангийн нэг төрөл болох Нийгмийн даатгалын санг тухайлан зохицуулсан зохицуулалтуудыг хассан байна.

1.2.3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3-т “Засгийн газрын тусгай сан” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.3-т “Засгийн газар, орон нутгийн тусгай сан” гэж орон нутгийн тусгай сангийн мэдээллийг нэмсэн.

Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан, орон нутгийн тусгай сан гэсэн төрөлтэй байна” гэж заасны дагуу орон нутгийн тусгай сангийн мэдээллийг нэмсэн гэж үзэхээр байна.

1.2.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.5-д “Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.5-д “Засгийн газар, орон нутгийн өр, авлага үүсгэсэн шийдвэр, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл” гэж тодруулсан.

1.2.5. Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.6-д “Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж” гэж оруулсан байх хэдий ч зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг шилэн дансны мэдээлэлд хамааруулаагүй байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.6-г “Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж болон түүгээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа” гэж өөрчлөх.

1.2.6. Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.8-д “... бусад тусламж, хандив” гэж Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.6-д байгаа “Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж” гэснээс бусад тусламж, хандивын мэдээллийг нэмсэн.

Иргэний нийгмийн байгууллагаас өгсөн санал:

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын томоохон хэсгийг санхүүжүүлдэг гадаад, дотоодын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг иж бүрэн хангуулах асуудлыг Шилэн дансны тухай хууль тогтоомжид нарийвчлан тусгаж, боловсронгуй болгох.

(Нээлттэй Нийгэм Форум, 2021)

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.8-д “тусламж, хандив” гэсний өмнө “зээл” гэж нэмэх.

- 1.2.7. Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.2.9-д “хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл” гэж хуулийн үйлчлэлд хамаарах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал, эдгээртэй холбоотой мэдээллийг нэмсэн байна.
- 1.2.8. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх; тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэж шилэн дансны зарчмыг, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-аар цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг тодорхойлсон байна. Шинэчилсэн найруулгын төслийн 4 дүгээр зүйлд шилэн дансны зарчмыг хэвээр үлдээсэн байна.

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дахь хэсэгт хуулийн 3.1.1, 3.1.3-т заасан байгууллага, албан тушаалтны мэдээлэх мэдээллүүдийг жагсаасан.

- 1.2.9. Шилэн дансны тухай хуулийн 6.2-т “Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна” гээд 6.2.1 – 6.2.6 дахь заалтыг, мөн хуулийн 6.3-т “Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна” гээд 6.3.1 – 6.3.9 дэх заалтыг хассан байна. Харин эдгээрээс Шилэн дансны тухай хуулийн 6.3.2, 6.3.5, 6.3.7, 6.3.9 дэх заалтад дурдсан агуулга Шинэчилсэн найруулгын төсөлд туссан бол бусад нь тусгагдаагүй байна.

Дээрх заалтуудыг хасах нь шилэн дансны мэдээлэл иж бүрэн байх, ач холбогдолтой байх зарчмуудад нийцэхгүй байна.

Санал:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 6.2.1 - 6.2.6 дахь заалтууд, 6.3 дахь хэсэг, 6.3.1, 6.3.3, 6.3.4, 6.3.6 дахь заалтуудыг хэвээр үлдээх.

- 1.2.10. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор” гэж заасныг Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “Улсын Их Хурал

болон тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголыг батлагдсанаас хойш долоо хоногийн дотор” гэж өөрчилсөн.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д дурдсан “*тухайн жилийн төсөв*” гэснийг “Улсын Их Хурал болон тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөл” болгон өөрчилж, төсөв гэснийг хассан байна. Гэтэл Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т төсвийн төсөл гэж, 4.1.5-д төсөв гэж тусад нь тодорхойлсон. Харин худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Шинэчилсэн найруулгын төслийн 6.1.3-т төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор гэж, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг Шинэчилсэн найруулгын төслийн 6.1.6-д тусгасан байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.3-т заасан этгээд, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын саналыг УИХ болон тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхээс хоёр сарын өмнө шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулна” **гэж нэмэх**;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1 - 6.13 дахь хэсгийн дугаарлалтыг 6.2 - 6.14 **гэж өөрчлөх**;

Шинэчилсэн найруулгын төслийн 6.1.1-д “Улсын Их Хурал болон тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөл” гэсний дараа “тухайн жилийн төсөв” **гэж нэмэх**.

- 1.2.11. Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7-д “*тусгай сангийн эх үүсвэр, зарцуулалтын батлагдсан дүнг батлагдсанаас хойш долоо хоногийн дотор*” гэж нэмсэн. Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “*Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан, орон нутгийн тусгай сан гэсэн төрөлтэй байна*” гэж заасан тул Шинэчилсэн найруулгын төсөлд “тусгай сан” гэх ерөнхий нэр томъёог хэрэглэсэн байна.

Иргэний нийгмийн байгууллагаас өгсөн санал:

Засгийн газрын тусгай сангуудын төсвийг зарцуулах сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудлыг Шилэн дансны тухай хууль тогтоомжид нарийвчлан тусгаж, боловсронгуй болгох;

(Нээлттэй Нийгэм Форум, 2021)

- 1.2.12. Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.3.7, 6.10.2-т “*байгууллагын хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэлд орсон өөрчлөлт*” гэж нэмсэн.

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллага, албан тушаалтанд Засгийн газар, орон нутгийн тусгай санг оруулсан. Гэвч Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д “*Энэ хуулийн 7.1.8, 7.1.9-д олон улсын байгууллага, Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл хамаарахгүй бөгөөд улсын бүртгэлд бүртгэхгүй*” гэж заасан.

Тодруулбал, Засгийн газар, орон нутгийн тусгай сангулсын бүртгэлд бүртгэхгүй тулхуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орох тухай ойлголт байхгүй. Иймд Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн 6.3.7-д заасан мэдээллийг мэдээлэх боломжгүй байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлд “энэ хуулийн 6.3.7-д заасан мэдээлэх үүрэг энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллагад хамаарахгүй” гэж нэмэх.

1.2.13. Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.3.10-т “*төрийн өмчийн эд хөрөнгийг актлах, устгах*” гэж нэмсэн. Ийнхүү акталж, устгахад гүйлгээний утгыг шилэн дансанд маш тодорхой оруулах шаардлагатай. Тухайлбал, өндөр үнэтэй Ланд 200 авто машиныг акталж байгаа нэрээр эрх баригч, удирдлагууд маш бага үнээр өөрсдөө авсан байдаг. Иймд гүйлгээний утгыг маш тодорхой нэр зааж, анхны худалдаж авсан үнэ, дуудлага худалдаагаар хэн авсан, авсан хүний албан тушаал, нэр тодорхой байх шаардлагатайг төсөв судлаачид дурдсан байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.3.10-т “*төрийн өмчийн эд хөрөнгийг актлах, устгах тухай шийдвэр, гүйлгээний утга, актлах эд хөрөнгийн анхны үнэ, дуудлага худалдааны үнэ, авсан хүний нэр, албан тушаал*” гэж өөрчлөх.

1.2.14. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 6.3.5-д “*таван сая төгрөг буюу түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл, түүнд холбогдох гэрээ, шийдвэр*” гэж, Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 6.3.4-т “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөг буюу түүнээс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэл*” гэж өөрчилсөн.

Ингэхдээ хуульд тусгайлан дурдсан нэр, санхүүжилтийн хэмжээ, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, нийлүүлэгчийн нэр, хаяг гэснийг “*дэлгэрэнгүй мэдээлэл*” гэж өөрчилсөн байна. Энэ нь гүйлгээний мэдээлэл ач холбогдолтой байх зарчим алдагдах, бодит өгөгдөл оруулахгүй байх эрсдэлтэй.

Дээрхээс гадна Шинэчилсэн найруулгын төслийн 6.3.11-д “*хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь таван сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь таван сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй бол энэ хуулийн 6.3.4-т заасны нэгэн адил мэдээлнэ*” гэж нэмсэн.

Шилэн дансны тухай хуульд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий санхүүгийн мэдээллийг нээлттэй байршуулахаар хязгаарлалт тогтоож байгааг иргэний нийгмийн байгууллагууд төрийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдээлэл авах эрхийг хязгаарлаж байна, үнийн дүнгээс хамаарахгүйгээр бүхий л худалдан авалт, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг ил болгох шаардлагатай гэж өөрчлөх санал гаргаж байсан.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.3.4-ийг “цалингийн зардлаас бусад таван сая төгрөг буюу түүнээс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний шийдвэр, огноо, хүлээн авагч болон шилжүүлэгчийн нэр, банкны дансны дугаар, гүйлгээний утга, тэмдэглэл, гүйлгээний бусад дэлгэрэнгүй мэдээлэл” гэж өөрчлөх;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.3.5-ыг “таван сая төгрөг буюу түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, бараа, ажил, үйлчилгээ авах шийдвэр, санхүүжилтийн хэмжээ, түүнд холбогдох гэрээ, хүлээн авагчийн нэр, гүйлгээний утга, гүйлгээний бусад дэлгэрэнгүй мэдээлэл” гэж өөрчлөх.

- 1.2.15. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.3-т “Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээллийг улирал бүр” гэж заасныг Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т “Засгийн газрын гадаад, дотоод өрийн бүтэц, өрийн хэрэгсэл, өрийн үйлчилгээний мэдээллийг улирал бүр, дараа сарын 15-ны өдрийн дотор” гэж өөрчилсөн.

Өрийн удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өр болон өрийн баталгааны үлдэгдлийг улирал бүр, дунд, урт хугацааны өрийн үйлчилгээний төсөөллийг жил бүр тооцоолон гаргаж, олон нийтэд мэдээлнэ” гэж, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “Засгийн газрын өрийн баталгаа”-г зээл, өр, өрийн хэрэгсэл, өрийн үйлчилгээнээс тусад нь байхаар тодорхойлж хуульчилсан. Харин тус хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өрийн удирдлагын ил тод байдлыг хангах зорилгоор улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны талаар жилд нэг удаа олон нийтэд мэдээлнэ” гэж мэдээлэх давтамж нь жилд нэг удаа байхаар заасан.

Дээрх хуулийн зохицуулалтад тусгагдсан мэдээлэх хугацааны давтамжийг Шинэчилсэн найруулгын төсөлд нэмж, мэдээлэх хугацааг тодорхойлсон боловч мэдээллийн агуулгыг тусгайлан зохицуулж буй хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т “Засгийн газрын гадаад, дотоод өрийн бүтэц, хэрэгсэл, өрийн үйлчилгээний мэдээллийг ...” гэснийг “Засгийн газрын гадаад, дотоод өр, өрийн бүтэц, өрийн хэрэгсэл, өрийн үйлчилгээ, өрийн баталгаа болон зээлдүүлэгч, тэдгээрийн хүү, зориулалтын мэдээллийг Засгийн газрын болзошгүй өрийн мэдээллийн хамт” гэж өөрчлөх.

- 1.2.16. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1-д “тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр” гэж заасныг Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.10.5-д “тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7-д заасан шийдвэр” гэж агуулгын хувьд хэвээр үлдээсэн. Энэ зохицуулалт нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдэд хамааралтай зохицуулалт байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.10.5-д “тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7-д заасан шийдвэр...” гэснийг “тухайн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох аливаа зээл, өр, төлбөр бий болгосон шийдвэр, өр төлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл, гэрээ хэлцэл, гэрээний тал, гэрээний хугацаа, хүү, гэрээгээр тохирсон валют, зориулалтын мэдээлэл” гэж өөрчлөх.

- 1.2.17. Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд”-ийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх төсөв, санхүүгийн мэдээллийг тусгасан хэдий ч хязгаарлагдмал мэдээлэл оруулсан.

Зарим компани таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээг зөвхөн “төрийн өмчийн үйлдвэрийн газар” гэж албан ёсоор бүртгээгдсэн аж ахуйн нэгжүүдэд хамаарах хуулийн заалт гэж үзээд тайлагнадаггүй байсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. ... ТӨК-ууд гүйлгээний үндэслэл болсон шийдвэрийн хуулбарыг бараг 100 хувь оруулдаггүй, мөн дансны дугаар, тухайн данс бүртгээгдсэн банк болон гүйлгээний утга, тэмдэглэл зэрэг мэдээллийг тэр бүр оруулаагүйг ажиглаж болно.

(Н.Дорждарь, 2022)

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.10-ыг “Энэ хуулийн 3.1.2-т заасан этгээд, албан тушаалтан энэ хуулийн 6.3.4, 6.3.5, 6.3.11-д зааснаас гадна дараах мэдээллийг тухайн шийдвэр гарсан, үйл ажиллагаа хэрэгжсэнээс хойш долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж өөрчлөх;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.10.9-ийг “Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын урамшуулал, цалингийн хэмжээг тогтоосон шийдвэр болон шилэн дансны мэдээлэлд хамаарах асуудлыг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол” гэж өөрчлөх;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.10.10-т “Тухайн байгууллагын ханган нийлүүлэлтийн болон бүтээгдэхүүн худалдах, зуучлан борлуулах, тээвэрлэх, түгээх зорилгоор хувь хүн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ” гэж нэмэх;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.10.11-д “Төрөөс санхүүжүүлж хэрэгжүүлэх төсвийн болон нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээний шийдвэр, төсөв, төлөвлөгөө” гэж нэмэх.

- 1.2.18. Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.11-д “Энэ хуулийн 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан санхүүгийн хэрэгжилт, гүйцэтгэлд хийсэн хяналт, тайлагналын талаар дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гээд дөрвөн мэдээлэл нэмсэн. Үүнээс 6.11.1-д “хагас жилийн санхүүгийн тайланг гаргаснаас хойш” гэж заасан нь ерөнхий байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.11.1-д “хагас жилийн санхүүгийн тайланг гаргаснаас хойш” гэснийг “Улирлаар гардаг тайланг тухайн улирлын тайлан гаргаснаас хойш, хагас жилийн Санхүүгийн байдлын, Орлого, үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний тайланг нэмэлт тайлбарын хамт тухайн тайланг гаргаснаас хойш” гэж өөрчлөх.

Шинэчилсэн найруулгын төслийн 2 дугаар зүйлийн 2.1-д “Шилэн дансны тухай хууль тогтоомж нь ... Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ... бүрдэнэ” гэж заасан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (НМИТБТХ) 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ба иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт бий болгох харилцааг зохицуулсан.

Нийтийн мэдээлэл хариуцагч гэдэгт дараах 5 байгууллагыг ойлгоно. Үүнд:

- төрийн байгууллага (НМИТБТХ 6.1.1);
- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд (НМИТБТХ 6.1.2);
- хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд (НМИТБТХ 6.1.3);
- олон нийтийн радио, телевиз (НМИТБТХ 6.1.4);
- улс төрийн нам (НМИТБТХ 6.1.5).

Мэдээлэл хариуцагч нь өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх 10, хүний нөөцийн талаарх 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх 28, хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаарх 2, өөрийн эрхлэх асуудлын хүрээний 22, нийт 68 мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан ил тод, нээлттэй байлгана.

Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх 28 мэдээллээс дараах мэдээллүүд нь Шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдаагүй байна. Үүнд:

- Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ (НМИТБТХ 8.4.4);
- Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар (НМИТБТХ 8.4.5, 8.4.18);
- Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл (НМИТБТХ 8.4.9);
- Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл (НМИТБТХ 8.4.21);
- Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл (НМИТБТХ 8.4.24);
- Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан (НМИТБТХ 8.4.27).

Иймд төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахтай холбоотой нээлттэй байлгах мэдээллийг Шинэчилсэн найруулгын төсөлд дараах байдлаар тусгах шаардлагатай. Тодруулбал, мэдээлэх мэдээллийн агуулгыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан ч мэдээлэх хугацаа тодорхойгүй байгааг Шинэчилсэн найруулгын төсөлд тусгах замаар уялдаа холбоог хангах шаардлагатай.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.2-т “хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлсэн төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний төрөл, хэмжээний мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор” гэж нэмэх;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Төсвийн алдагдал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод, гадаад үнэт цаасны мэдээлэл” гэж нэмэх;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.5.1-ийг “Монгол Улсын нэгдсэн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлт, түүний тайлбарын хамт дараа сарын 15-ны өдрийн дотор” гэж өөрчлөх.

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа этгээдийг, 3.1.5-д төрийн чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдийг хуулийн үйлчлэлд хамаарахаар тусгасан. Гэвч Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлд заасан шилэн дансны мэдээллийг мэдээлэх этгээдэд оруулаагүй, 3.1.4, 3.1.5-д заасан этгээд ямар мэдээлэл тавих талаар хуульчлаагүй орхигдуулсан. Иймд хуулийг хэрэгжүүлэх субъект гэж тусгасан бол мэдээлэх төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал, эдгээртэй холбоотой мэдээллийг мэдээлэх үүргийг төсөлд тусгах шаардлагатай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй” гэснийг хассан.

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.5-д “Энэ хуулийн 6 дугаар зүйлд тусгайлан заагаагүй, бусад хууль тогтоомжоор хориглоогүй энэ хуулийн 3.2-т хамаарах мэдээллийг нээлттэй мэдээлж болно” гэснээс үзэхэд мэдээлэх мэдээллийг 6 дугаар зүйлд тусгаагүй тохиолдолд мэдээлэхгүй орхигдуулах эрсдэлтэй байна. Тиймээс шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг тодорхой хугацаанд мэдээлдэг байх нь Шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа хуулийн хэрэгжилтийг хангахад чухал нөлөөтэй гэж үзэж байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.12-т “Энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд, албан тушаалтан энэ хуулийн 6.2.5, 6.2.8, 6.3.4, 6.3.5, 6.3.9, 6.3.11, 6.9.4, 6.10.2, 6.10.5, 6.10.7-д заасан мэдээллийг тогтоосон хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байрлуулахад төлбөр төлөхгүй” гэж нэмэх;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.13-т “Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг арга хэмжээг хэрэгжүүлснээс хойш 7 хоногийн дотор мэдээлнэ” гэж нэмэх.

1.3. Цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, мэдээлэл тавих журам, хэлбэрийн шаардлагыг хуулиар бус журмаар тогтоох хэрэгцээ, хэрэгжилтийн үр дагавар

1.3.1. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийн талаарх зохицуулалтын агуулгыг Шинэчилсэн найруулгын төсөлд хэвээр үлдээсэн. Зөвхөн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батлахаар заасныг өөрчилсөн байна.

Хуулиар төрийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэг, ямар гүйлгээг мэдээлэх талаар зохицуулсан. Гэвч Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандарт тогтоох журмыг хуульчилж, боловсронгуй болгох хэрэгцээ үүссэн байна. Тодруулбал, шилэн дансанд мэдээлэл оруулах стандарт байхгүйгээс мэдээлэл оруулахад нэг компани, хувь хүний нэрийг олон янзаар бичих, гүйлгээг төрлөөр ангилахгүй оруулдгаас дараа нь гүйлгээг хянах, оруулсан өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд хүндрэл үүсгэж, шилэн дансны мэдээллийн ач холбогдлыг бууруулж байх тул шилэн дансанд өгөгдөл оруулах стандарт маягт бий болгох бодит шаардлага бий болсон.

Шилэн дансыг хариуцагчийн хувьд Сангийн яам цахим санд нэмэлт хөрөнгө оруулалт хийж өгөгдлийн тайлагнал, хандалтыг хялбаршуулан, хэрэглэгчдэд дөхөм болгох замаар мэдээллийн хадгалалт, шинэчлэлийг сайжруулах шаардлагатай. Ихэнх өгөгдлийг тусгай маягтаар дамжуулан стандартчилсан байдлаар хүлээн авч байх шаардлагатай. Өгөгдлийг олон төрөл, хэлбэрээр татаж авах боломжтой болгох ёстой бөгөөд өгөгдлийн хураангуй тайланг сонирхсон талуудын янз бүрийн хэрэгцээнд нийцүүлэн дүрсжүүлж, дэлгэрүүлж гаргах шаардлагатай.

(Н.Дорждарь, 2022)

Мөн хүлээн авсан хандив, тусламжийг мэдээлдэг хэдий ч тухайн орлогыг юунд зарцуулсан талаарх мэдээлэл бүрэн биш, ойлгомжгүй, мэдээллийг татаж авах боломжгүй, орлогыг хаанаас өгснөөр хайх боломжгүй байдаг. Мөн зардлыг төрөл, зориулалтаар нь бус зөвхөн төсөв захирагч, байгууллагаар хайх боломжтой зэргээр шилэн дансанд өгөгдөл оруулах нэгдсэн стандарт байхгүй нь шилэн дансны мэдээллийн ач холбогдлыг бууруулах, ил тод байдал хангагдахгүй байх эрсдэл үүсгэж байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 5 дугаар зүйлийн 5.1-ийг “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд өөрийн цахим хуудсанд шилэн дансны бие даасан цэстэй байх бөгөөд шилэн дансны нэгдсэн цахим хуудастай холбосон байна” гэж өөрчлөх (*shilendans.gov.mn* сайт руу ороход “Шилэн дансны мэдээллийн систем” гэж нэрлэсэн байна);

Шинэчилсэн найруулгын төслийн 5 дугаар зүйлийн 5.2-ыг “Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулах шилэн дансны мэдээлэл нь дараах шаардлагыг хангасан байна:

5.2.1. мэдээлэл нээлттэй өгөгдлийн форматаар, татаж авах, компьютерт уншуулах, дахин ашиглах, хэвлэх боломжтой байх;

5.2.2. тодруулга өгөх албан тушаалтны нэр, албан тушаал, харилцах утас, цахим хаягийг байршуулсан байх;

5.2.3. мэдээллийг шилэн дансны өгөгдлийн стандартын дагуу оруулж, тайлбар, тэмдэглэл бичигдсэн байх;

5.2.4. мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх.

- 1.3.2. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шилэн дансны нэгдсэн цахим хуудастай байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас ажиллуулж эхлэх хугацааг энэ хуулийн хэрэгжилтийн байдлыг харгалзан Засгийн газар 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө байхаар тогтоох бөгөөд уг нэгдсэн цахим хуудсыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шилэн дансны нэгдсэн цахим хуудастай байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө” гэж агуулгын хувьд хэвээр үлдээсэн.

Гэвч дээрх зохицуулалтын улмаас Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах үүрэг бүхий этгээдэд зөвхөн Сангийн яамыг ойлгодог, өөрсдийн ил тод байдлыг хариуцахгүй байх асуудал практикт үүссээр иржээ. Иймд Шилэн дансны тухай хуулийн дээрх зохицуулалтын агуулгыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийтлэх мэдээллийг мэдээлэх үүрэг бүхий этгээд хариуцах, харин Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны ажиллах хэвийн, найдвартай, тасралтгүй ажиллагааг Сангийн яам хариуцахаар хуульчлах шаардлагатай.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэвийн, тасралтгүй ажиллагаа, өгөгдлийн стандартчилал, тайлагнал, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлж мэдээллийг дүрсжүүлж, хураангуйлах, хандалтыг хялбаршуулан хэрэглэгчдэд хүргэхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна” гэж өөрчлөх.

- 1.3.3. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Энэ хуулийн 5.1, 5.3-т заасан цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална” гэснийг Шинэчилсэн

найруулгын төслийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Энэ хуулийн 5.1, 5.3-т заасан цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж өөрчилсөн. Тодруулбал, цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журмыг Сангийн яам бие даан батлахаар заасан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудасны стандартыг Сангийн яам батлахаар Шинэчилсэн найруулгын төсөлд өөрчилж тусгасан байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д шилэн дансны мэдээллийг байгууллагын нэр, орлого, зарлагын ангиллын төрөл, төсөл, арга хэмжээний нэр, кодоор хайлт хийх, мэдээллийг татаж авах, тайлагнасан мэдээллийг нэг цонхонд харах зэрэг талаар нарийвчлан зохицуулаагүй. Иймд Сангийн яамнаас батлах цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, журамд дараах гол ангилал, формат, шаардлагыг зайлшгүй тусгах шаардлагатай.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 5.4-ийг “Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж өөрчлөх;

Шинэчилсэн найруулгын төслийн 5.5-ыг “Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан, өгөгдөл нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн тусгасан, дараах шаардлагыг хангасан байна:

5.5.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан шилэн дансанд өгөгдөл оруулах маягтаар дамжуулан стандартчилсан байдлаар хүлээн авсан байх;

5.5.2. Шилэн дансны мэдээлэл нь төрөлжсөн, байгууллагын нэр, орлого, зарлагын ангиллын төрөл, төсөл, арга хэмжээний нэр болон кодоор хайлт хийх, тайлагнасан бүх хугацааны мэдээллийг нэг цонхонд харах, компьютерын программд боловсруулагдах форматаар татаж авч болохуйц байх;

5.5.3. Шилэн дансны мэдээллийн нэгдсэн систем нь Татвар, гаалийн мэдээллийн систем, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийн бааз, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн систем, Нийтийн мэдээллийн нэгдсэн систем зэрэг төрийн мэдээллийн системүүдтэй автоматаар холбогдон мэдээлэл солилцож, баталгаажуулсан байх;

5.5.4. Бодит өгөгдөл оруулсан тохиолдолд хүлээн авах, бодит өгөгдөл оруулаагүй тохиолдолд тэмдэглэл бичигдсэн байх.

- 1.3.4. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасан нь Шинэчилсэн найруулгын төсөлд хэвээр байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудсаар мэдээлсэн эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж өөрчлөх.

1.4. Мэдээллийн агуулга, мэдээлэх давтамжийг тодорхойлсон нэмэлт, өөрчлөлт

1.4.1. Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.5-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.6-д зааснаас гадна дараах мэдээллийг мэдээлнэ гэж заасан. Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор” гэж, 6.2.5-д “хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийн улирлын мэдээллийг төсөл, объект тус бүрээр дараа сарын 08-ны өдрийн дотор” гэж, 6.5.2-т “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг улирал бүр, дараа сарын 15-ны өдрийн дотор” гэж заасан.

Тодруулбал, Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д “...үйл ажиллагааны төлөвлөлтийн талаарх”, 6.2-т “гүйцэтгэлийн талаарх” мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлэхээр заасан. Улмаар хуулийн 6.1.5-д хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт буюу төлөвлөлтийг, 6.2.5-д хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийн улирлын мэдээлэл буюу гүйцэтгэлийг мэдээлэхээр байна. Гэтэл төслийн 6.5.2 дахь заалтаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг улирал бүр, дараа сарын 15-ны дотор мэдээлэхээр тусгасан нь дээрх заалтуудтай давхардал үүсгэнэ.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын “жагсаалтыг” гэснийг “төлөвлөгөөг” гэж, 6.2.5 дахь заалтын “санхүүжилтийн улирлын мэдээллийг” гэснийг “санхүүжилт, гүйцэтгэлийн улирлын мэдээллийг” гэж өөрчлөх;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.5.2. “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг улирал бүр, дараа сарын 15-ны өдрийн дотор” гэснийг хасах.

Концессын тухай хуулийн 6, 7 дугаар зүйлд концессын талаар төрийн, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг тусад нь зохицуулсан. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6-д зааснаар концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь “концессын зүйлийн жагсаалтыг нийтэд мэдээлэх”, 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн өмчийн “концессын зүйлийн жагсаалтыг нийтэд мэдээлэх” бүрэн эрхтэй байна. Иймд Шинэчилсэн найруулгын төсөлд төрийн болон орон нутгийн өмчийн концесст хамаарах мэдээллийг мэдээлэх үүргийг өөр өөр этгээд хэрэгжүүлэх Концессын тухай хуулийн зохицуулалтад нийцүүлж, холбогдох саналыг дараах байдлаар гаргаж байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.6-д “концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэсний дараа “болон аймаг, нийслэлийн Засаг дарга” гэж нэмэх.

1.5. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих субъектийг тодорхойлсон байдал, тэдгээрийн бусад хууль тогтоомжоор тодорхойлсон чиг үүрэг, эрх хэмжээний уялдаа холбоо

1.5.1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн

8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурлын хяналт тавих үйл ажиллагааны журмыг төрийн аудитын дээд байгууллага боловсруулан баталж мөрдүүлнэ” гэж өөрчилсөн.

Тодруулбал, иргэдийн Төлөөлөгчдийн болон иргэдийн Нийтийн Хурлаас хөндлөнгийн хяналт тавих үйл ажиллагааны журмыг төрийн аудитын байгууллагаас батлахаар нэмсэн нь иргэний нийгмийн байгууллагаас гаргасан дараах саналд дурдсан хяналтыг бодитоор хэрэгжүүлэх хууль зүйн үндэслэл бүрдүүлсэн байна. Харин мэдээлэх зохицуулалтыг Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлд нэмж оруулахаар өмнөх хэсэгт санал гаргасан болно.

Иргэний нийгмийн байгууллагаас өгсөн санал:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанид хөндлөнгийн хяналт тавих байгууллага нь шат шатны ИТХ байхаар зохицуулсан нь оновчтой зохицуулалт болж чадахгүй байна. Иймд ТӨК-ийн дотоод хяналтын нэгжийг үр дүнтэй ажиллуулж, тэрхүү хяналт нь дээд шатны байгууллага, төрийн хяналтын байгууллага болон хараат бус хөндлөнгийн аудитаар дахин хянагддаг, түүнийг олон нийтэд мэдээлдэг үр дүнтэй тогтолцоо бий болгох шаардлагатай.

(Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл, Нээлттэй Нийгэм Форум, 2021)

1.5.2. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны...” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллага, албан тушаалтны...” гэж өөрчилсөн нь иргэний нийгмийн байгууллагын саналыг Шинэчилсэн найруулгын төсөлд тусгаж, төрийн өмчит үйлдвэрийн газар болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн төсвийн ил тод байдалд хяналт тавих хууль зүйн үндэслэл бүрдүүлсэн байна.

Иргэний нийгмийн байгууллагаас өгсөн санал:

Орон нутгийн төсвийн ил тод байдлыг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг төсвийн захирагчид ханган ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулах;

(Нээлттэй Нийгэм Форум, 2017)

Шилэн дансны тухай хуульд Төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалах төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, төрийн өмчийн оролцоотой компаниудын төсвийн ил тод байдлыг хангуулах, хяналт тавих асуудлыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасантай уялдуулан боловсронгуй болгох.

(Нээлттэй Нийгэм Форум, 2021)

- 1.5.3. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т *“Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж болно”* гэснийг Шинэчилсэн найруулгын төсөлд өөрчлөөгүй.

Мэдээлэх албан тушаалтан, мэдээллийн төрөл, хугацааг хуулиар тухайлан заасан хэдий ч мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан үүргээ биелүүлэхгүй байх, төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хангалттай, үр дүнтэй хэлбэрээр ил тод болохгүй байх эрсдэлтэй. Иймд хуулиар хүлээлгэсэн үүргийн биелэлтэд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх үр дүнтэй механизм байх ёстой. Гэтэл Шилэн дансны тухай хуульд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх Төрийн аудитын байгууллага аудит *“хийж болно”* гэж сонгох боломжтой зохицуулалт байгаагаас хуулийн хэрэгжилтэд тавих хөндлөнгийн хяналт бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 8 дугаар зүйлийн 8.3-ыг *“Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж, аудитын тайлан, үр дүн болон өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар өөрийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийт, иргэний нийгмийн байгууллагад мэдээлнэ” гэж өөрчлөх.*

- 1.5.4. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т *“Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно”* гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн мөн хэсэгт *“Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг харгалзан үзнэ”* гэж өөрчилсөн. Тодруулбал, хуулийн хэрэгжилтийг “гол үзүүлэлт болгоно” гэснийг хасаж, хуулийн хэрэгжилтийг харгалзан үзэхээр заасан.

Гэхдээ хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт, аудитын талаар тухайн байгууллагын дотоод журам, ажлын горимд тусгаагүй, удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээнд багтаагүй байдгаас хяналт хангалттай, үр дүнтэй хэмжээнд хэрэгждэггүй. Улмаар хуулийн үйлчлэлд хамаарах 3.1-д заасан эд хөрөнгө захиран зарцуулах албан тушаалтан хариуцлага хүлээхгүй байх тохиолдол гардаг.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 8 дугаар зүйлийн 8.4-ийг *“Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах байгууллагын дотоод журам, ажлын горимд, эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн үнэлгээнд энэ хуулийн хэрэгжилтийг хангах талаар тусгаж, байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт болгоно” гэж өөрчлөх.*

- 1.5.5. Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д *“Энэ хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно”* гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлийн 9.1-д *“Энэ*

хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно” гэж өөрчилсөн. Тодруулбал, гомдол, мэдээлэл гаргах субъектээр “хуулийн этгээдийн эрхгүй байгууллага” гэж нэмсэн нь Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна” гэсэнтэй нийцсэн байна.

- 1.5.6. Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Иргэн, хуулийн этгээдийн татвар төлөгчийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн мөн хэсэгт “Иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэж өөрчилсөн. Тодруулбал, нэхэмжлэл гаргах харьяаллыг захиргааны хэргийн шүүх гэж тухайлан заасныг хассанаас гадна эрх ашиг гэснийг “эрх, хууль ёсны ашиг сонирхол” гэж Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгтэй нийцүүлсэн байна. Харин Шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлийн 9.1-д гомдол, мэдээлэл гаргах этгээдээр хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг нэмсэн атлаа шүүхэд гомдол гаргах эрхтэй этгээдэд оруулаагүй орхигдуулсан байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “хуулийн этгээдийн” гэснийг “хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын” гэж өөрчлөх.

1.6.Хариуцлага ногдуулах хуулиуд, тэдгээрийн үндэслэлийн хамрах хүрээ, үр дагавар

Шилэн дансны тухай хуулийн 10.1-д “...Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 10 дугаар зүйлийн 10.1-д “...Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж өөрчилсөн.

Иргэний нийгмийн байгууллагаас өгсөн санал:

Шилэн дансны тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарч буй үүрэг хүлээсэн этгээд нь Төрийн албаны тухай хуулийн үйлчлэх хүрээний этгээд болон Хөдөлмөрийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах этгээд байх тул хуулийн хариуцлагыг “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж өөрчлөх.

(Сангийн яам, 2021)

Шинэчилсэн найруулгын төсөлд тус саналыг бүрэн тусгасан хэдий ч төслийн 10.1-д “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан нь Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх механизмыг тусгасан

байна. Хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн этгээдэд хариуцлага оногдуулах харилцааг Зөрчлийн тухай хуулиар зохицуулж байна. Гэтэл Шилэн дансны тухай хууль болон Шинэчилсэн найруулгын төсөлд уг хуулийг зөрчсөн буруутай тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг зөвхөн эрүүгийн хариуцлага буюу гэмт хэргийн шинжтэй эсэхээр хязгаарласан байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд гаргасан зөрчил нь эрүүгийн, эсхүл зөрчлийн шинжтэй байхаас үл хамаарч ажилтанд сахилгын шийтгэл оногдуулах боломжтой ч уг хуулийн заалтад нийцүүлэх шаардлагатай. Тодруулбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д “Хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, ажлын байрны тодорхойлолтыг зөрчсөн ажилтны буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг сахилгын зөрчилд тооцно” гэж, мөн хуулийн 123.2-т “Ажил олгогч буюу түүнээс эрх олгосон удирдах ажилтан сахилгын зөрчил гаргасан ажилтанд дараах хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулна” гэж заасан. Үүнээс ажилтны хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод шилэн дансны үйл ажиллагааг хариуцах тухай заагаагүй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д заасан сахилгын зөрчилд Шилэн дансны тухай хууль зөрчсөн үйлдэл хамаарахгүй, мөн хуулийн 123.2-т заасны дагуу сахилгын зөрчил биш үйлдэлд хөдөлмөрийн сахилгын шийтгэл оногдуулахгүй юм.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Энэ хуулийн 3.1 дэх хэсэгт заасан байгууллага шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн, олон нийтэд хүргэх үүргийг өөрийн дотоод зохион байгуулалтын нэгжээр гүйцэтгүүлж болно” гэснийг “Энэ хуулийн 3.1 дэх хэсэгт заасан байгууллага шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн, олон нийтэд хүргэх үүрэг бүхий албан тушаалтныг томилж, түүний гүйцэтгэх ажил, үүрэгт оруулж, хуулийн хэрэгжилтийг хангаж болно” гэж өөрчлөх;

Шинэчилсэн найруулгын төслийн 10 дугаар зүйлийн 10.1-д “... гэмт хэргийн шинжгүй бол ...” гэснийг “гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол” гэж өөрчлөх.

ХОЁР. ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

2.1. Хуулийн төслийн бүтэц, хэлбэр, бичвэр, хэл зүй, найруулгад тавигдах шаардлагад нийцсэн байдал

Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулах шаардлагатай. Тус хуулийн 28 дугаар зүйлд “Хуулийн төслийн бүтэц, хэлбэр”, 29 дүгээр зүйлд “Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага”, 30 дугаар зүйлд “Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэх шаардлага”-ыг тус тус тодорхойлсон.

2.1.1. 29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.6-д “Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.6-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасан нь зөрчилтэй байна. Тодруулбал, 6.6 дахь хэсэгт “6.6” гэж эшилсэн зөрчилтэй байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгээс “... 6.6 ...” гэснийг хасах.

- 2.1.2. 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;

Бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төсөл боловсруулсан эсэх нь тодорхойгүй. Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хавсралтаар оруулаагүй байна.

- 2.1.3. 29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.

Шилэн дансны тухай хууль нэг талаас төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах эрх зүйн орчин бүрдүүлэх, нөгөө талаас иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах зорилготой. Иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрх хангагдсанаар төрийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх эрх зүйн орчин бүрдүүлэх зорилго хангагдах учиртай. Харин Шинэчилсэн найруулгын төслийн 1.1-д иргэний үндсэн эрх болох “иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах” зорилгыг дурдаагүй байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “...зорилгоор” гэсний өмнө “иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах” гэж нэмэх.

- 2.1.4. 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;

Шинэчилсэн найруулгын төслийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэж заасан. Энд иргэн, олон нийтэд гэсэн үгний хороонд таслал тавиагүйгээс нэг ойлголт мэт харагдуулж байна. Гэвч, НМИТБтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.7, 8 дугаар зүйлийн 8.8, 32 дугаар зүйлийн 32.1.18-д олон нийтэд гэсэн үгийг дангаар нь хэрэглэсэн.

Ийнхүү төслийн 7.1-д иргэн, олон нийт гэсэн хоёр үгний хооронд таслал тавиагүй нь НМИТБтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.7, 8 дугаар зүйлийн 8.8, 32 дугаар зүйлийн 32.1.18 дахь заалтын нэр томъёотой нийцэхгүй.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 7 дугаар зүйлийн 7.1-д “... иргэн олон нийтэд ...” гэснийг “олон нийтэд” гэж өөрчлөх.

Шинэчилсэн найруулгын төслийн 2 дугаар зүйлийн 2.1-д “... Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль ...” гэж заасныг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль” гэж өөрчлөх.

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “*төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд*” гэж заасан нь ТБОНӨТХ-ийн 21 дугаар зүйл дэх “*төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд*” гэсэн нэр томъёотой нийцэхгүй.

Гэсэн ч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “*төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд*” гэх нэр томъёог мөн ашигласан.

2.1.5. 30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;

Санал:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “байгууллага” гэснийг Шинэчилсэн найруулгын төслийн 3.1-д “эрх зүйн этгээд” гэж өөрчилсөн хэдий ч төслийн бусад хэсэгт “байгууллага” гэдэг үг хэвээр байх тул үүнийг нэг мөр болгож хэрэглэх шаардлагатай;

Шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.4-т “... нийтэд мэдээлэхээс ...” гэсэн нэр томъёо ашигласан боловч 9.2-т “... олон нийтэд мэдээлнэ” хэмээн нэг ойлголтыг ялгаатай томъёоллоор илэрхийлжээ. Иймд тус нэр томъёог “олон нийт”, эсхүл “нийт” гэж нэг мөр томъёолох шаардлагатай.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд нийцсэн байдал

2.1.6. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 5.4. Огнооны бичилт хэсэг дэх 5.4.1-д хуулийн төсөлд огноог үсэг, тооны холимог байдлаар тэмдэглэж болно. Тухайлбал, оныг 4 оронтой тоогоор, сар, өдрийг тухайн сар, өдрийн тоогоор, “1990 оны 5 дугаар сарын 1-ний өдөр” гэж ганц тоогоор илэрхийлэгдэх сар, өдөр байвал тэдгээрийн өмнө “0” хэрэглэхгүй.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.8.2, 6.8.3 дахь заалтад “... 01 дүгээр сарын ...” гэснийг “1 дүгээр сарын” гэж өөрчлөх.

2.2. Бусад хууль тогтоомжид нийцсэн байдал

Шинэчилсэн найруулгын төслийн бусад хууль тогтоомжид нийцсэн байдлыг нэгдүгээр бүлэгт дурдсан хуулиудаас гадна Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Банкны тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудад төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, төрийн өмч, хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, мэдээлэхтэй холбоотой зохицуулалтын хүрээнд шалгахад дээр дурдсанаас өөр шууд зөрчилдөх зүйл, заалт тусгагдаагүй байна.

2.2.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “*Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол*

мэдээлнэ” гэж заасан. Харин Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.2.8-д “тусгай сангаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг улирал бүр, дараа сарын 08-ны өдрийн дотор” гэж мэдээлэх хугацааг улирлаар тогтоосон.

Сараар болон улирлаар мэдээлэх нь агуулгын хувьд давхцахгүй хэдий ч нэг төрлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх хугацааг зөрүүтэй тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-д заасан зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх, 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасан хоёрдмол утгагүй байх гэсэнд нийцэхгүй байна.

Мөн Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.7.2-т “аудит хийсэн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитын дүгнэлтийн бүрэн эхийн хамт дараа оны 5 дугаар сарын 10-ны дотор” гэж заасан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д “Тусгай сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ” гэж заасантай зөрчилдөж байна. Тодруулбал, жилийн төсвийн зарцуулалт буюу төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын дүгнэлтийн хамт нийтлэх хугацааг зөрүүтэй тусгасан. Иймд дараах байдлаар хууль тогтоомжийн нийцлийг хангахаар байна.

Санал:

Шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.2.8-д “улирал бүр” гэснийг хасах;

Шинэчилсэн найруулгын төслийн дагалдах хуулийн төсөлд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг оруулж, тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг “Тусгай сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ” гэж өөрчлөх.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны багийн зүгээс Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хүчин төгөлдөр мөрдөж байгаа Шилэн дансны тухай хуультай харьцуулан судлахаас гадна хуулийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд иргэний нийгмийн байгууллага, төрийн аудитаас өгсөн санал, зөвлөмжийг тусгасан эсэхэд дүгнэлт хийж, холбогдох санал, зөвлөмж боловсрууллаа. Эдгээрийг тоймловол:

- Шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн үйлчлэлд хамаарах эрх зүйн этгээд, эрх бүхий албан тушаалтан, мэдээлэх мэдээллийн төрлүүдийг дахин томьёолж давхардлыг арилгасан байна. Гэхдээ зарим зүйл, заалтад тусгасан нэр томьёо, агуулга, томьёолол нь бусад хуульд хэрэглэсэн нэр томьёо, мэдээллийн төрөл, агуулгыг тусгасан зохицуулалттай нийцээгүйг харьцуулан судлах замаар өөрчлөх, хасах, мөн шинээр нэмж тусгах саналуудыг энэхүү шүүмжээр гаргалаа.
- Шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн үйлчлэлд хамаарах таван төрлийн этгээдийг тодорхойлсон ба Засгийн газрын болон орон нутгийн тусгай санг шинээр нэмсэн байна. Иймд хуулийн үйлчлэлд хамрагдвал зохих этгээд бүрэн хамрагдсан эсэхийг тодорхойлох зорилгоор төсөлд тодорхойлсон этгээдүүдийг бусад хууль тогтоомжид заасантай уялдуулах, нийцүүлэх, иргэний нийгмийн байгууллагын санал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайланд тусгагдсан саналуудыг

харгалзан нэмэлт, өөрчлөлтийн санал дэвшүүлээ.

- Шилэн дансны мэдээллийг төсөв, төлөвлөлт болон гүйцэтгэл гэсэн үндсэн хэсгүүдэд хувааж, мэдээллийн төрөл, хугацааг мэдээлэх үүрэгтэй этгээдэд ялгаатай байдлаар тусгасан. Мөн хуулийн төсөлд тухайн шатны төсвийн захирагчийн мэдээлэх мэдээллийг нэмж, концесстой холбоотой санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээлдэг байсан мэдээллийг концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэхээр өөрчилж, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад байгууллагын мэдээлэх мэдээллийг хассан. Ингэхдээ Шинэчилсэн найруулгын төсөлд мэдээлэх үүрэгтэй байхаар заасан төрийн чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдийг орхигдуулсан нь тухайн этгээдийг мэдээлэх үүргээс чөлөөлөх эрсдэл бий болгосон тул холбогдох хэсэгт нэмэлт оруулах санал гаргалаа.
- Хуулийн үйлчлэлд хамаарах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийн агуулга, хамрах хүрээнд мэргэжлийн зөвлөхүүд болон иргэний нийгмийн байгууллагуудын өгсөн саналыг харгалзан төсөлд тусгагдсан тодорхойгүй зүйл, заалтыг тодруулах, нарийвчилсан харилцааг зохицуулж буй хуулиудад нийцүүлэхээр холбогдох саналыг томъёолсон.
- Шилэн дансны тухай хуульд нэгдсэн цахим хуудсыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө гэж зааснаар шилэн дансанд мэдээлэл оруулах үүрэг бүхий этгээдүүд уг үүргийг зөвхөн Сангийн яамны чиг үүрэг мэт ойлгож болзошгүй хоёрдмол утга бий болгож байсан. Иймд шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг мэдээлэл оруулах үүрэг бүхий этгээд бүр хөтлөх, Сангийн яам цахим хуудасны хэвийн, найдвартай ажиллагааг хангах гэж өөрчилснөөр төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах ач холбогдолтой.
- Улсын төсөв, санхүүгийн ил тод байдал нь иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахад чиглэдэг тул иргэд шилэн дансны мэдээллийг ойлгомжтой, хялбар авах боломжийг хууль тогтоомжоор бүрдүүлэх шаардлагатай. Шилэн дансны тухай хуулийн дагуу, одоо мөрдөгдөж буй журам ёсоор иргэд шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл авахад ойлгомжгүй, хүндрэлтэй асуудал цөөнгүй тулгардаг талаар иргэний нийгмийн байгууллагуудын санал болон хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайланд тусгагджээ. Тиймээс цахим хуудас дахь мэдээллийн төрлийг сайжруулах, формат, татаж авах боломжийг хангах зохицуулалтыг Шинэчилсэн найруулгын төсөл болон журам, нийтлэг стандартад тусгуулах, нэгдсэн системийн хөгжүүлэлт, шинэчлэл хийх санал гаргалаа.
- Шинэчилсэн найруулгын төсөлд хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь таван сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь таван сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй бол нэгэн адил мэдээлэхээр нэмсэн нь мэдээлэл иж бүрэн, ач холбогдолтой байх зарчимд нийцсэн байна. Иймд таван сая төгрөг ба түүнээс дээш үнийн дүн бүхий гүйлгээний мэдээллийн ил тод байдлыг хангаж, гүйлгээ хийх тухай шийдвэр, гүйлгээний огноо, хүлээн авагч болон шилжүүлэгчийн нэр, банкны дансны дугаар, гүйлгээний утга, тэмдэглэл, гүйлгээний бусад дэлгэрэнгүй мэдээллийг шилэн дансанд оруулж байхаар нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргалаа.
- Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан мэдээлэх албан тушаалтанд өөрчлөлт оруулаагүй хэдий ч байгууллага шилэн дансны мэдээллийг олон нийтэд хүргэх үүргийг өөрийн дотоод зохион байгуулалтын нэгжээр гүйцэтгүүлж болохоор

хуульчилсан. Ийнхүү дотоод зохион байгуулалтын нэгжээр буюу ажилтнаар гүйцэтгүүлэх боломж олгосноор хуулийн 7.1-д заасан албан тушаалтныг хариуцлагаас чөлөөлөхгүй гэх агуулга хэвээр үйлчлэхээр байна.

- Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хуульчилсан хэдий ч тэрхүү хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байсныг тодруулах зорилгоор хяналт тавих үйл ажиллагааны журамтай байх, уг журмыг төрийн аудитын дээд байгууллага боловсруулан баталж мөрдүүлэхээр төсөлд нэмсэн байна.
- Шилэн дансны хөтлөлт хууль, нийтлэг стандартын дагуу явагдаж буй эсэхэд хамаарах иргэний гомдлыг төрийн аудитын байгууллага шийдвэрлэх бөгөөд гомдол, мэдээллийн дагуу арга хэмжээ авч, үр дүнг иргэнд бичгээр мэдэгдэж, олон нийтэд мэдээлэх одоогийн хуулийн зохицуулалтыг Шинэчилсэн найруулгын төсөлд хэвээр үлдээсэн байна.
- Иргэн, хуулийн этгээдийн шүүхэд хандах эрхийг татвар төлөгчийн эрх ашиг зөрчигдсөн гэдгээр хязгаарлаж байсан бол эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар өөрчлөлт оруулсан нь гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болохоор байна.
- Хууль зөрчсөн албан тушаалтанд Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр нэмэлт оруулсан боловч хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд сахилгын шийтгэл оногдуулахад тавигддаг уг хуулийн зохицуулалтыг хангасны дараа хариуцлага хүлээлгэх боломжтойг анхаарах шаардлагатай. Мөн мэдээлэх үүрэгтэй албан тушаалтны хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөвхөн гэмт хэргийн шинжтэй тохиолдлоор хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг хязгаарласан бөгөөд Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах замаар “зөрчил”-д тооцох зохицуулалтыг дагалдах хуулийн төсөлд нэмэх шаардлагатай.

Хавсралт №1. Иргэний нийгмийн байгууллага, төсөв, эдийн засгийн экспертүүдийн өгсөн санал, шүүмж


Шилэн дансны тухай хууль 2014 онд батлагдсанаас хойш төрийн аудитын байгууллагаас гадна иргэний нийгмийн байгууллагууд хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх замаар санал, зөвлөмж гаргаж ирсэн. Тухайлбал, ННФ нь 2015, 2016, 2017, 2019 онд нийслэл, дүүрэг, аймгуудын Засаг даргын Тамгын газрын шилэн дансанд мониторинг хийж, үр дүнг нь олон нийтэд таниулах ажлыг, “Үнэн хатамж” ТББ, “Захиргааны шинэ санаачилга” ТББ зэрэг иргэний нийгмийн бусад байгууллагаас төсвийн шууд захирагчдын шилэн дансанд мониторинг хийж иржээ.

Иймд төсөв судлаач, эдийн засагчид болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс өмнө нь хүргүүлсэн саналыг Шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан эсэх, Шинэчилсэн найруулгын төсөл нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шилэн дансны тухай хуулийн зохицуулалтыг сайжруулсан эсэх, мөн Шинэчилсэн найруулгын төсөлд тусгах шаардлагатай санал, өгөх шүүмж байгаа эсэхийг тодруулах зорилгоор дараах асуулгын хүрээнд фокус бүлгийн оролцогчдоос ярилцлага авсан. Үүнд:

1. Өмнөх зөвлөмж, дүгнэлтүүдэд тусгасан санал төсөлд тусгалаа олсон уу?
2. Төсөлд нэмэгдсэн болон өөрчлөгдсөн, хассан зохицуулалтууд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг сайжруулж чадсан уу?
3. Өмнөх зөвлөмж, дүгнэлтүүдэд тусгасан саналаас төсөлд тусгаагүй, тусгах шаардлагатай гэж үзэж байгаа санал, зөвлөмж байгаа юу?
4. Төсөл нь нийтийн төсөв, санхүүг бүхлээр нь ил тод болгосон уу? Төсөлд нэмж хамруулах шаардлагатай төсөв, санхүүгийн харилцаа байгаа юу?
5. Шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэр нь иргэдэд ээлтэй, хүртээмжтэй байхаар тусгагдаж чадсан уу?
6. Төсөлд хариуцлагын механизм оновчтой туссан уу?
7. Төсөлд өгөх өөр санал, шүүмж байгаа юу зэрэг болно.

№	Төлөөлөл	Фокус бүлгийн ярилцлагын оролцогч
1	Төсөв судлаач	Эдийн засагч Н.Энхбаяр
2		Эдийн засагч Ц.Ганчимэг
3	Иргэний нийгмийн байгууллага	“Үнэн хатамж” ТББ-ын Гүйцэтгэх захирал Ж.Сайнзаяа
4		“Ил тод байдал сан” ТББ-ын Гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав
5		“Захиргааны шинэ санаачилга” ТББ-ын Гүйцэтгэх захирал С.Цэрэнпүрэв
6		Либерал эмэгтэйчүүдийн оюуны сангийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн Гүйцэтгэх захирал Ч.Ганцэцэг
7		“Эх нутаг хөгжил төв” ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Төмөртоогоо

Фокус бүлгийн оролцогчид Шинэчилсэн найруулгын төслийг хэрхэн үнэлсэн байдлыг хариултаар нь хувьчлан үзүүлбэл:



Фокус бүлгийн оролцогчдын дийлэнх нь Шинэчилсэн найруулгын төсөл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шилэн дансны тухай хуулийн зохицуулалтыг сайжруулсан, мөн өмнөх санал, шүүмжийг тусгасан гэж дүгнэсэн ба дараах саналуудыг онцолсон юм. Үүнд:

- Санал 1:** Төслийн 6.3.5-д заасан таван сая төгрөг буюу түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл, түүнд холбогдох гэрээ, шийдвэрийг нээлттэй байршуулах талаар хязгаарлалт тогтоосныг хасаж, үнийн дүнгээс хамаарахгүйгээр зарлагын бүх гүйлгээг ил болгох;
- Санал 2:** Шилэн дансны вебсайтыг байгууллагын санхүүгийн системтэй холбох;
- Санал 3:** Шилэн дансанд бэлэг, урамшуулал, шагналын мэдээлэл оруулах;
- Санал 4:** Шилэн дансны системд 4-5 жил тутам хөндлөнгийн байгууллагаар мониторинг хийлгэж үнэлүүлэх;
- Санал 5:** Шилэн данс хөтлөх харилцааг нарийвчлан зохицуулж буй журмыг хоёр жил тутам шинэчлэхээр тусгах;
- Санал 6:** Шилэн данс хөтлөлтийн хугацаа өнгөрсөн ч хөтлөхгүй байгаа тохиолдолд анхааруулга илгээх, улмаар анхааруулга өгснөөс хойш мэдээллээ оруулаагүй тохиолдолд “санаатай зөрчил” гэж үзэж ялгаатай хариуцлага ногдуулах;
- Санал 7:** Шилэн данс хөтлөх этгээдийг нарийвчлан тодорхойлох, чадваржуулах арга хэмжээ авах;
- Санал 8:** Мөнгөн бус хандив тусламжийн талаар тодорхой болгох, мөнгөн бус хандивыг үнэлгээгээр оруулах;
- Санал 9:** Шилэн данс дахь нэр томъёог тодорхой болгох шаардлагатай. Тодруулбал, “Мэдээлэл байхгүй болно”, “Тавигдах мэдээлэл байхгүй болно” бус “Ийм зарцуулалт байхгүй болно” гэх зэргээр нарийн, ойлгомжтой оруулах;
- Санал 10:** Төсвийн зарцуулалттай холбоотой бүх шийдвэрийн бүртгэл хийдэг байх, бүртгэлийг шилэн дансанд оруулдаг байх;
- Санал 11:** Ил тод байдлыг нэг сайтаар хэрэгжүүлэх;
- Санал 12:** Байгууллагууд шилэн дансны мэдээллээ сайт, сонинд заавал тавина гэдэг заалт оруулж өгөх. Сум, орон нутгийн хувьд аймгийнхаа сонин болон сайтад, мөн өөрийн байгууллагын пэйж хуудсанд заавал байршуулах;

- Санал 13:** Гүйлгээний утга маш тодорхой байхаар заах. Тухайлбал, өндөр үнэтэй Ланд 200 ч юм уу машиныг акталж байгаа гээд эрх баригч, удирдлагууд маш бага үнээр өөрсдөө авсан байдаг. Тэгвэл үүнийг мэдээлэхдээ гүйлгээний утгыг маш тодорхой, нэр зааж тавих. Жишээлбэл, анхны худалдаж авсан үнэ, дуудлага худалдаагаар хэн авсан, авсан хүний албан тушаал, нэр тодорхой байх, тухайлбал, “Анх 140 сая төгрөгөөр худалдаж авсан ЛАНД 200 машиныг 5 жил 6 сар төрийн өмчид ашиглаж, Бат овогтой Болд дуудлага худалдаагаар 16 сая төгрөгөөр авав” гэж гүйлгээний утгаа тодорхой бичих;
- Санал 14:** Тухайн гүйлгээ рүү ороод харахад гүйлгээний баримт нь харагддаг байх.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2019 он
2. Банкны тухай хууль, 2010 он
3. Захиргааны ерөнхий хууль, 2015 он
4. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019 он
5. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он
6. Концессын тухай хууль, 2010 он
7. Монгол Улсын Үндсэн Хууль, 1992 он
8. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2020 он
9. Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, 2021 он
10. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, 2021 он
11. Өрийн удирдлагын тухай хууль, 2015 он
12. Төрийн аудитын тухай хууль, 2020 он
13. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 1996 он
14. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2005 он
15. Төсвийн тухай хууль, 2011 он
16. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, 2020 он
17. Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он
18. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он
19. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021 он
20. Шилэн дансны тухай хууль, 2011 он
21. Засгийн газрын 2016 оны 39 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам
22. Сангийн сайдын 2016 оны 41 дүгээр тушаалын хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тогтоох журам

Ном, сурах бичиг, судалгаа

1. Авлигатай тэмцэх газар, IRIM судалгааны хүрээлэн, С.Бадамханд, Б.Эрдэнэ, Н.Янжинпагма, Б.Түвшинзаяа. Төрийн байгууллагын вэбсайтын ил тод байдал - мониторингийн тайлан. 2012 он.
2. ННФ. Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2016 (Судалгааны тайлан). 2017 он.
3. Үнэн хатамж ТББ. Аудитын дүгнэлт. 2018 он.
4. Үндэсний аудитын газар. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан. 2020 он.
5. Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын тайлан. 2020 он.
6. ННФ. Төрийн аудитын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн төсөлд өгөх санал. 2020 он.
7. ННФ. Төрийн аудитын зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилт. 2021 он.
8. ННФ, Г.Дэлгэрмаа, С.Боргил, Б.Анхзаяа. Төсвийн гадуурх зарцуулалт: Цар тахлын үеийн бодлоготой холбоотойгоор уул уурхайн салбар дахь төрийн өмчийн хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэсэн төсвийн гадуурх зарцуулалт ба холбогдох мэдээллийн бүрэн, ил тод байдал. 2021 он.
9. ННФ, Аудитор Д.Отгонбаяр, Ц.Цэрэннамжил, оюутан Б.Учрал нар. “Шилэн дансны тухай хууль, журмын чиглэлээр төрийн аудитын байгууллагаас гаргасан дүгнэлтүүдэд үндэслэсэн эрх зүйн судалгаа”. 2021 он.
10. ННФ, О.Батболд, Г.Батнасан, С.Болд-Эрдэнэ, Б.Зоригтхүү нар. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компани - Худалдан авалтын үйл ажиллагааны ил тод байдал. 2021 он.
11. Сангийн яам. 2014 онд батлагдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан. 2021 он.
12. Сэтгүүлчид. “Төрийн өмчит уул уурхайн компаниудын шилэн дансанд мэдээллийн дүн шинжилгээ хийх” төслийн тайлан. 2021 он.
13. Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд. Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал. 2021 он.
14. Н.Дорждарь. “Монголын төрийн өмчит уул уурхайн компаниуд: Шилэн дансны мэдээллийн гүнд”. 2022 он.

Цахим эх сурвалж

1. News.mn. “Шилэн дансанд хийсэн “амьгүй” аудит” нийтлэл. 2020 он. (<https://news.mn/r/2376915/>)
2. Ikon.mn. “Шилэн дансны тухай хуулийн цоорхой ба төрийн өмчит компаниудын ялгавартай ил тод байдал” нийтлэл. 2021 он. (<https://ikon.mn/n/248a>)
3. Eagle.mn. “Шилэн данс-ширэн нүүр” нийтлэл. 2018 он. (<http://eagle.mn/r/51508>)

Хуулийн шүүмж боловсруулсан:
Өмгөөллийн Фиделитас партнерс ХХН-ийн судалгааны баг

Дугаар эрхэлсэн:
Нээлттэй нийгэм форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Монгол Улс
Улаанбаатар-14240
Сүхбаатар дүүрэг
Жамъян гүний гудамж-5/1
Утас: (976) 76113207
Веб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn